



МОНГОЛ УЛСЫН  
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2021 оны 09 сарын 29 өдөр

Дугаар A/151

Улаанбаатар хот

Г

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 22.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн тушаах нь:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан баталж, мэргэжил, арга зүйн удирдлага, зохион байгуулалтаар ханганд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Дамбий/-т даалгасугай.

3. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг эрхэлсэн салбар болон харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороо, салбар хороо, зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

САЙД



А.АРИУНЗАЯА

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын  
2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/151  
дугаар тушаалын хавсралт

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН  
2021 -2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуульд “иргэн бүр хөдөлмөрийн таатай нөхцөлөөр хангуулах эрхтэй” гэж заасан. Үндсэн хуулийн энэхүү заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрх зүйн орчин бүрэлдэн тогтсон. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн харилцаанд Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль голлох үүрэгтэйгээр хэрэгжиж байна.

Монгол Улсын Засгийн газраас Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (ХАБЭА) үндэсний хөтөлбөрийг (1997-2020 оны хооронд) хэрэгжүүлж, хууль эрх зүй, дүрэм журам, стандартыг сайжруулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тогтолцоо болон хөдөлмөрийн хяналтыг бэхжүүлэх, эрүүл, аюулгүй ажлын байр, орчин нөхцөлийг бий болгох, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд бий болгох ажлуудыг хэрэгжүүлсэн.

Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулдаг байсан ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдалтай холбоотой харилцааг 2008 онд баталсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиар зохицуулдаг болсон. Уг хуульд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага, зохион байгуулалт, хяналт, ажил олгогч, ажилтны үүрэг, хариуцлага, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ, түүний санхүүжилт зэрэг нийтлэг шаардлагуудыг тусгасан.

Түүнчлэн Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын 155 (Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай), 167 (Барилгын аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай), 176 (Уурхай дахь аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай) дугаар конвенцуудад нэгдэж, аж ахуйн нэгж, байгууллагад ХАБЭА-н менежментийн тогтолцоо хэрэгжүүлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний урьдчилан сэргийлэлтэд нийгмийн түншлэлийн оролцоог нэмэгдүүлэх, ХАБЭА-н ажилтан, мэргэжилтнүүдийг бэлтгэх, боломж нөхцөл бүрдсэн.

Үндэсний хөтөлбөрүүд тасралтгүй, тогтвортой хэрэгжсэний үр дүнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль эрх зүй, бүтэц тогтолцоо сайжирч, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний урьдчилан сэргийлэлтэд ахиц дэвшил гарсан гэж үзэж байна. Гэсэн хэдий ч ажиллагчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлэхийн зэрэгцээ цар тахал, шинэ технологи, шинэ ажил мэргэжил, аж үйлдвэржилтийн өсөлт зэргээс шинээр бий болж буй аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрүүл, бүтээмжтэй ажиллах хүчээр эдийн засгийг дэмжих асуудал чухлаар тавигдаж байна.

2020 онд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын 353 тохиолдол бүртгэгдэж, үүний улмаас 40 хүн амь наасаа алдсан. Олон улсад хийгдсэн судалгаагаар амь нас хохирсон үйлдвэрлэлийн ослын нэг тохиолдол нь амь нас хохироогүй ослын 800 тохиолдолтой шууд хамааралтайг тогтоосон. Манай улсад жилд 32 мянгаас цөөнгүй үйлдвэрлэлийн ослын тохиолдол тохиолддог хэдий ч бүртгэл, мэдээлэл хангалттай хийгдэхгүй байна. 2019 оны байдлаар нийгмийн даатгалын сангаас мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр

хөдөлмөрийн чадвар алдсан 3037 хүн тэтгэвэр авч байгаа тооцоо судалгаа байна. Гэвч үндэсний статистикийн нэгдсэн санд мэргэжлээс шалтгаалсан өвчний тоо статистик бүртгэгдэхгүй байгаа нь албан бус мэдээллийг бий болгоход хүргэж байна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний урьдчилан сэргийлэх арга хэмжээг үндэсний түвшинд хэрэгжүүлэхэд мэргэжлийн хүний нөөц хүрэлцэхгүй байгаа нь 2018 онд хийсэн судалгаанаас харагдаж байна. Тухайлбал 10,000 ажилтан тутамд 29 ХАБЭА-н ажилтан, 0.9 хөдөлмөрийн эрүүл ахуйч, 0.3 хөдөлмөрийн эрүүл мэнд судлаач эмч оногдож байгааг тогтоосон. Аж ахуйн нэгж, байгууллагын ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтнуудын 7% нь их сургуульд мэргэжил эзэмшсэн, 93% нь түр сургалтын төвүүдэд бэлтгэгдсэн мэргэжлийн бус хүмүүс байна.

2019 онд мэргэжлээс шалтгаалсан өвчин үүсэх өндөр эрсдэлтэй нөхцөлд ажилладаг 224 мяняган хүний 11.3% нь хөдөлмөрийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан. Өндөр эрсдэлтэй 29,425 аж ахуйн нэгжийн 0,8% нь ажлын байрандаа хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэсний 30% нь эрүүл ахуйн стандартын шаардлага хангагүй байна. Түүнчлэн цар тахлын нөхцөлд аж ахуйн нэгж байгууллага бизнесийн үйл ажиллагаагаа эрсдэлгүй зохион байгуулах, ажлын байранд бий болсон халдвартыг бүртгэх, урьдчилан сэргийлэх зэрэг асуудлууд шинээр тулгамдах болсон. Эдгээр нөхцөл байдал нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн бодлого төлөвлөлтөд эрүүл мэндийн асуудлыг онцгой анхаарах шаардлагатайг илтгэж байна.

Эдгээр тоо баримт, нөхцөл байдлаас харахад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хөтөлбөрийн залгамж бодлогыг үргэлжлүүлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний урьдчилан сэргийлэх арга хэмжээг үндэсний түвшинд төлөвлөх, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

## Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, зарчим

### 2.1 Хөтөлбөрийн зорилго

Хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтны эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдлыг хамгаалах төрийн бодлого, зарчмыг хэрэгжүүлэх, үр нөлөөтэй нийгмийн түншлэл бүхий хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ажилтан бүр эрүүл, аюулгүй хөдөлмөрийн орчин нөхцөлийг бий болгоход чиглэнэ.

### 2.2 Хөтөлбөрийн зорилт

Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлнэ.

2.2.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож, уялдаа холбоог нь сайжруулна;

2.2.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлага зохион байгуулалт, хамтын ажиллагааг өргөжүүлнэ;

2.2.3 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний урьдчилан сэргийлэлтэд хөдөлмөрийн хяналтын үр нөлөөг нэмэгдүүлнэ;

2.2.4 Аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгож, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний урьдчилан сэргийлэлтийг сайжруулна;

2.2.5 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн боловсрол, сургалт, статистик эрдэм шинжилгээний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

## 2.3 Хөтөлбөрийн зарчим

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд дараах зарчмыг мөрдөнө.

- Монгол Улсад мөрдөгдөж буй хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрх зүйн баримт бичиг нэгдмэл, уялдаа холбоотой, давхцалгүй байх;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхэд идэвхтэй урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээг дэмжих;
- Нотолгоонд суурилсан, ил тод, эрсдэлтэй бүлэгт чиглэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Урьдчилан сэргийлэлтэд нийгмийн түншлэлийн оролцоо, үр нөлөөг нэмэгдүүлэх, мэдээллийн нээлттэй байдлыг дэмжих;
- Төрийн байгууллага, нийгмийн түншлэл, бусад сонирхогч талууд хооронд болон салбар дундын хамтын ажиллагааны уялдаа холбоог хангах,
- Олон Улсын хэм хэмжээ, чиг хандлагатай уялдуулах.

Гурав. Хөтөлбөрийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож, уялдаа холбоог нь сайжруулах 1 дүгээр зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.1.1 Хөдөлмөрийн эрүүл мэндийн үйлчилгээ, асбесттай холбоотой өвчний урьдчилан сэргийлэлт, хөдөлмөрийн хяналт, хөдөө аж ахуйн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаарх хууль тогтоомжийг сайжруулсан Олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенцуудад нэгдэх;

3.1.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн холбогдох эрх зүйн баримт бичгүүдэд үнэлэлт дүгнэлт хийж, түүний хэрэгжилтэд оролцдог төрийн байгууллагуудын чиг үүргийн хуваарилалтыг оновчтойгоор сайжруулж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний бүртгэл мэдээлэл, ажлын байрны дарамт, бэлгийн дарамт, ажилтны эрүүл мэндийн үзлэг тандалт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжилтний ажил үүрэг, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний бодлогын хэрэгжилтийн санхүүжилтийг тодорхой болгох асуудлыг зохицуулах;

3.1.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн олон улсын зарчимтай нийцүүлэн шинэчилж, талуудын эрх, үүрэг, байгууллагын түвшний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлагын тогтолцоо, нийгмийн түншлэл, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний бүртгэл мэдээлэл, ажлын байрны дарамт, бэлгийн дарамт, ажилтны эрүүл мэндийн үзлэг тандалт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжилтний ажил үүрэг, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний бодлогын хэрэгжилтийн санхүүжилтийг тодорхой болгох асуудлыг зохицуулах;

3.1.4 Хөдөлмөрийн хяналтын тогтолцоо, хууль эрх зүйн орчныг сайжруулж, хяналтын бүрэн эрх, төлөвлөгөөт бус хяналтын чадамж, чадавхыг баталгаажуулах, бичил бизнес, жижиг үйлдвэр, хөдөө аж ахуйн хяналтыг сайжруулах, албан бус салбар, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд зөвлөн туслахад чиглэсэн зохицуулалтыг хийх;

3.1.5 Бичил бизнес, албан бус салбар, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн асуудлыг зохицуулсан хуулиудад үнэлгээ хийж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл

мэндийн сургалт, боловсролыг дэмжих, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээг урамшуулахад чиглэсэн зохицуулалтуудыг бий болгох;

3.1.6 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний бүртгэл, мэдээллийг сайжруулах, эрүүл мэндийн болон хөдөлмөрийн нөхөн сэргээх тусlamж үйлчилгээг нэмэгдүүлэх, үр дүнтэй урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн ажил олгогчийг урамшуулах, албан бус, бичил бизнес эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн дэмжлэг үзүүлэх, урьдчилан сэргийлэлтийн урамшууллын тогтолцоог бий болгох асуудлыг тусгах;

3.1.7 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний бүртгэл, мэдээллийн дүрэм, журмыг хянаж, мэдээллийн технологид суурилсан хялбар, үр дүнтэй, бүртгэл, мэдээллийн тогтолцоог нэвтрүүлэх;

3.1.8 Ажилтны эрүүл мэндийн үзлэг, тандалтын арга зүйг шинэчилж, ажилтны эрүүл мэндэд хийх ажил хөдөлмөрийн тохирооны үнэлгээ, мэргэжлээс шалтгаалсан өвчний илрүүлэлт, оношилгоо, ажил мэргэжилтэй холбоотой (КОВИД 19 зэрэг) халдвартыг бүртгэх, мэдээлэх арга зүйг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулах;

3.1.9 Бүх төрлийн асбест, асбест агуулсан материалын хэрэглээг Монгол Улсад хориглож, асбесттай холбоотой өвчний урьдчилан сэргийлэлт, илрүүлэлт, тандалтын зохицуулалтыг бий болгох.

3.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлага зохион байгуулалт, хамтын ажиллагааг сайжруулах 2 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.2.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжлийн байгууллагуудын чадавх, чиг үүргийн хэрэгжилтийн үр дүнг үнэлж, тоног төхөөрөмж, мэргэжлийн хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөг сайжруулах;

3.2.2 Мэргэжлээс шалтгаалсан өвчний идэвхтэй урьдчилан сэргийлэлт, ажилтны эрүүл мэндийн үзлэг тандалт, эрүүл мэндийн болон хөдөлмөрийн нөхөн сэргээх тусlamж үйлчилгээний чанар, хүртээмжийг эрүүл мэндийн үндэсний тогтолцоотой уялдуулан сайжруулах;

3.2.3 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний эрсдэлийг илрүүлэх, бүртгэх, хөдөлмөрийн хяналт, идэвхтэй урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд ашиглах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн бодлого, урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх, судалгаа, хяналтад ашиглах өгөгдлийн санг бий болгоход зориулж “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн харилцаа, тандалтын цахим систем”-ийг хөгжүүлэх;

3.2.4 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт илрүүлэх, оношлох арга зүйг сайжруулж, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн болон хөдөлмөрийн нөхөн сэргээх тусlamж үйлчилгээний хүртээмж, санхүүжилтийг нь нэмэгдүүлэх.

3.3 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хөдөлмөрийн хяналтын үр нөлөөг сайжруулах 3 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.3.1 Хөдөлмөрийн хяналтын чиглэлээр орон нутаг дахь бичил бизнес, хөдөө аж ахуйн салбарт хийх хөдөлмөрийн хяналтыг нэмэгдүүлж, албан бус салбар, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн зөвлөгөө, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

3.3.2 Ажлын байран дахь биологийн аюултай хүчин зүйлд тавих хөдөлмөрийн хяналтыг сайжруулж, аж ахуйн нэгж, байгууллага цар тахлын үед үйл ажиллагаа явуулахад зориулсан арга зүйн зөвлөгөө тусламжийг үзүүлэх;

3.3.3 Хөдөлмөрийн хяналтын чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагын аюулгүй ажиллагааны соёл, ослыг тэглэх алсын хараа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн сайн туршлагыг түгээн сурталчилж, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих;

3.3.4 Хөдөлмөрийн хяналтын улсын байцааг мэргэжлийн тусгай сургалтыг хөдөө аж ахуй, бичил бизнес, хувиараа хөдөлмөр эрхлэгч зэрэг салбарт биологийн аюултай хүчин зүйл, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчинөөс урьдчилан сэргийлэх эрсдэлийн үнэлгээний арга зүйн чиглэлээр тогтмол зохион байгуулах.

3.4 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн менежментийн тогтолцоог боловсронгуй болгож, аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд мэргэжлээс шалтгаалсан өвчиний урьдчилан сэргийлэлтийг сайжруулах 4 дүгээр зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.4.1 Аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчиний урьдчилан сэргийлэлт, дотоод хяналтыг сайжруулахад нийгмийн түншлэлийн оролцоог дэмжих асуудлыг байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлагын тогтолцооны чиг үүрэгт багтаан боловсронгуй болгох;

3.4.2 Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээнд суурилсан урьдчилан сэргийлэх (аюулыг илрүүлэх, эрсдэлийг үнэлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх) арга зүйг нэвтрүүлж, өндөр эрсдэлтэй аж ахуйн нэгжийн хамрагдах хувийг нэмэгдүүлж, зөвлөмжийн дагуу нөхцөлийг сайжруулах;

3.4.3 Аж ахуйн нэгж, байгууллагад зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлж, аюулгүй ажиллагааны соёл, хөдөлмөрийн нөхцөлөө сайжруулж, эрүүл аюулгүй ажлын байр бий болгосон байгууллагын бүтээмж, чанарын ахиц дэвшил, санхүүгийн үр ашгийг таниулан сурталчлах;

3.4.4 Аж ахуйн нэгж, байгууллагад зориулсан идэвхтэй урьдчилан сэргийлэлтийн зарчимд суурилсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээний арга зүйг боловсруулж, нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.4.5 Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны эрүүл мэндийн хугацаат үзлэг, тандалтын арга зүй, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, мэргэжлээс шалтгаалсан өвчиний эрт илрүүлэлт, хөдөлмөрийн чадвар алдалтын урьдчилан сэргийлэлт, статистик бүртгэл, мэдээллийг сайжруулах.

3.5 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн боловсрол, сургалт, статистик эрдэм шинжилгээнд дэмжлэг үзүүлэх 5 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.5.1 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний бүртгэл, мэдээлэл, статистикийг сайжруулж, үйлдвэрлэлийн ослын бүртгэлийн бодит түвшинг судлан тодорхойлох;

3.5.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн боловсрол, мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх бодлогыг боловсруулж, их, дээд сургуулиудад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн сургалт, эрдэм шинжилгээний үйл ажиллагааны чиглэлээр дэмжлэг үзүүлэх;

3.5.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн бодлого, шийдвэрийн үр нөлөөг үнэлэх нотолгоонд сууриссан арга зүйг боловсруулах, хэрэгжүүлэх чиглэлээр их, дээд сургууль, судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах;

3.5.4 Ажлын байран дахь стресс, ачаалал, хэт урт ажлын цаг, түүний үр дагавар зэрэг нийгэм сэтгэл зүйн хүчин зүйлс, биологийн аюул, цар тахал, шинэ технологи, ажил мэргэжлээр үүсгэгдэж буй үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг хамарсан эрдэм шинжилгээний ажлын тоог нэмэгдүүлж, бодлого, шийдвэрт ашиглах;

3.5.5 Ажилтны ажлын байрны аюул, эрсдэлийн талаарх боловсрол, эрдэм шинжилгээний ажлуудыг нэмэгдүүлж, үндэсний болон байгууллагын түвшинд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн бодлого, менежментэд тусгах нөхцөлийг бүрдүүлнэ.

Дөрөв. Хөтөлбөрийн үр нөлөө, шалгуур үзүүлэлт

#### 4.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүнд хүрэх:

4.1.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль эрх зүйн шинэчлэлийг идэвхтэй урьдчилан сэргийлэлт, зохицой хөдөлмөрийн зарчимд суурilan хийж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөг нь сайжруулж, Олон Улсын хөдөлмөрийн байгууллагуудын 81, 129, 161, 162, 184, 187 дугаар конвенцуудад нэгдэх бэлтгэл хангагдана;

4.1.2 Үндэсний түвшинд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлага зохион байгуулалтад оролцдог байгууллагуудын чиг үүргийг

оновчтойгоор зохион байгуулж, хамтын ажиллагааг нь сайжруулж, хууль тогтоомжийн хэрэгжилт, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний урьдчилан сэргийлэлтийн үр нөлөөг нэмэгдүүлнэ;

4.1.3 Бичил бизнес, жижиг үйлдвэр, албан бус салбар, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, хөдөө аж ахуйн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлыг хууль тогтоомжид тодорхой тусгаж, түүнийг хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, арга зүйн зөвлөн туслах үйлчилгээг нэвтрүүлнэ;

4.1.4 Өндөр эрсдэлтэй аж ахуйн нэгж, байгууллагад хийх ажилтны эрүүл мэндийн үзлэг, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг нэмэгдүүлэх, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт илрүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хөдөлмөрийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна;

4.1.5 Аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлагын тогтолцооны сайн туршлага, аюулгүй ажиллагааны соёлыг түгээн дэлгэрүүлж, нийгмийн түншлэлийн оролцоог нэмэгдүүлж, урьдчилан сэргийлэх

эрсдэлийн үнэлгээг нэвтрүүлж, ажилтны эрүүл мэндийн үзлэг, тандалтын үр нөлөөг сайжруулсан байна.

**4.1.6 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн боловсрол, сургалтын нэгдмэл бодлогыг боловсруулан, хэрэгжүүлсний дунд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мэргэжлийн хүний нөөцийн тоо нэмэгдэж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний статистик бүртгэл сайжирсан байна.**

#### 4.2 Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

##### Хөтөлбөрийн бүтээгдэхүүн, шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь үзүүлэлт 2021 он	Зорилтод түвшин				Мэдээлийн эх сурвалж	Хэрэгжүүлэх байгууллага
				2022	2023	2024	2025		
1	Олон улсын жишигт нийцсэн ХАБЭМ-ийн хууль тогтоомж	Нэгдэн орсон ОУХБ-ын конвенцийн тоо	3	3	3	3	9	ХНХЯ	ХНХЯ ХХАЯ МХЕГ
2	Эрсдэл өндөртэй салбарын ажилтнуудын эрүүл мэнд	ЭМ-ийн үзлэгт хамрагдсан ажилтнуудын эзлэх хувь	11.3%	15%	25%	35%	45%	ХАБЭМТ	ХНХЯ ЭМЯ ХАБЭМТ
3	Эрсдэл өндөртэй салбарын ААНБ-уудын хөдөлмөрийн нөхцөл	ХНҮ-нд хамрагдсан ААНБ-уудын эзлэх хувь /24.900 ААНБ/	0.8%	1.5%	2.5%	5%	10%	ХАБЭМТ	ХНХЯ МХЕГ ХАБЭМТ
4	Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийсэн ААНБ-ын тоо, /ажлын байраар/	ХНҮ-нд хамрагдсан нийт ААНБ, ажлын байрны тоо		190-1800	200-2000	230-2100	250-2500	ХАБЭМТ	ХНХЯ МХЕГ ХАБЭМТ
5	Ажилтны эрүүл мэндийн үзлэг, тандалт	Ажилтны ЭМ-ийн тусгайлсан үзлэг хийдэг эмнэлгийн тоо	3	3	6	10	25	ХАБЭМТ	ХНХЯ ЭМЯ
6	Олон улсын жишигт хүрч сайжирсан стандарт, техникийн зохицуулалт	Хянаж сайжруулсан, шинээр боловсруулсан стандарт, техникийн зохицуулалтын тоо	3	5	5	10	10	ХНХЯ	ХНХЯ
7	ХАБЭМ-ийн эрсдэл, харилцааны цахим тандалт	Цахим тандалтын системд холбогдсон өндер эрсдэлтэй ААНБ-ын эзлэх хувь	0	0	0	25%	50%	ХНХЯ	ХНХЯ
8	ХАБЭМ-ийн сайн туршлагын түгээн дэлгэрүүлэлт	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2	4	4	4	4	ХАБЭМТ	ХАБЭМТ
9	ХАБЭМ-ийн хяналтын чадавх	Нэг байцаагчид оногдох ХАБ, ХЭА-н мэргэжлийн сургалтын цагийн тоо	10	20	25	30	40	МХЕГ	МХЕГ
10	ААНБ-ууд дахь эрсдэлийн хяналт	ХЭМАБ-ын эрсдэлийн үнэлгээ хийсэн ААНБ-ын эзлэх хувь	1%	2%	5%	10%	20%	ХАБЭМТ	ХНХЯ ХАБЭМТ ААНБ-ууд
11	МШӨ-ийг эрт илрүүлэлт	ЭМ-ийн хугацаат үзлэгээр эрт үедээ илэрсэн МШӨ-ний тохиолдлын тоо**	10	20	35	35	35	ЭМЯ	ЭМЯ ХАБЭМТ ААНБ-ууд
12	Үйлдвэрлэлийн ослын бүртгэл, мэдээлэл	Үйлдвэрлэлийн ослын бүртгэлийн ОУ-ын дундажтай харьцуулсан утга*	85 дахин бага	80 дахин бага	70 дахин бага	60 дахин бага	50 дахин бага	МХЕГ	МХЕГ
13	МШӨ-ний бүртгэл, статистик	ЭМ-ийн нэгдсэн статистикт шинээр бүртгэгдсэн МШӨ-ний тохиолдлын тоо	0	0	34	34	34	ЭМЯ	ЭМЯ ХАБЭМТ
14	ХАБЭМ-ийн мэргэжлийн хүний нөөц	10,000 ажилтанд оногдох ХАБЭМ-ийн мэргэжилтний тоо	2	4	6	10	20	ХНХЯ	ХНХЯ Их дээд сургуулиуд
15		10,000 ажилтанд оногдох хөдөлмөрийн эрүүл ахуйч	0.9	1.2	2	10	20	ХНХЯ	ХНХЯ Их дээд сургуулиуд
16		10,000 ажилтанд оногдох хөдөлмөрийн эрүүл мэнд судлаач эмчийн тоо	0.3	0.3	0.6	5	10	ХНХЯ	ХНХЯ Их дээд сургуулиуд
17	ХАБЭМ-ийн эрдэм шинжилгээ	ХАБЭА-н чиглэлээр хийгдсэн судалгааны тоо	2	3	3	3	3	ХАБЭАҮХ	ХНХЯ ХАБЭАҮХ

		МШӨ-ний чиглэлээр хийгдсэн судалгааны тоо	0	1	1	2	2	ХАБЭАҮХ	ХХХЯ ХАБЭАҮХ
		Ажлын байран дахь нийгэм, сэтгэл зүйн хүчин зүйлс, хүйснээс хамаарсан эрсдэлийн талаарх судалгааны тоо	0	1	1	2		ХАБЭАҮХ	ХХХЯ ХАБЭАҮХ

## Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

5.1 Хөтөлбөрийг 2021 -2025 онд хэрэгжүүлнэ.

5.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс  
санхүүжүүлнэ.

5.2.1 улсын болон орон нутгийн төсөв;

5.2.2 үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын  
сангаас зарцуулах хөрөнгө;

5.2.3 олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

5.2.4 бусад эх үүсвэр.

## Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

6.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийг үндэсний хэмжээнд зохион байгуулах, салбар  
дундын бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангах  
үүргийг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв  
байгууллага, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороотой хамтран  
хэрэгжүүлнэ.

6.2 Төрийн захиргааны төв байгууллага, төрийн болон нутгийн захиргааны  
байгууллага нь салбарын, нутаг дэвсгэрийн болон байгууллагын хэмжээнд хөтөлбөрийг  
хэрэгжүүлэх арга хэмжээний тухайн жилийн төлөвлөгөө, төсөвтөө тусгах замаар  
хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, тайланг жил бүрийн 1 дүгээр сарын 15-ний дотор  
гаргаж, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв  
байгууллагад хүргүүлнэ.

6.3 Аж ахуйн нэгж, байгууллага бүр энэхүү хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааг  
жил бүрийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төлөвлөгөөндөө тусган  
хэрэгжүүлнэ.

6.4 Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг дараах талуудтай  
хамтран гүйцэтгэнэ.

6.4.1 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн  
захиргааны төв байгууллага;

6.4.2 Салбарын яамд, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн  
чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагууд;

6.4.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороо;

6.4.4 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо, зөвлөл.

6.4 Аймаг, нийслэл, дүүргийн түвшинд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 жил тутамд боловсруулан батлах, хэрэгжилтийг орон нутгийн засаг захиргааны болон төрийн бус байгууллага, ХАБЭА-н зөвлөлтэй хамтран хэрэгжүүлнэ.

6.5 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах чиг үүрэгтэй байна.

6.5.1 Хөтөлбөрийн зорилго, зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёр жил тутам боловсруулж, батлах;

6.5.2 Хөтөлбөрийн арга хэмжээний хэрэгжилтэд оролцогч талуудын тайлан мэдээ хүлээн авах, нэгтгэх, хэрэгжилтэд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

6.5.3 Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүр нэгтгэж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороонд танилцуулах;

Долоо. Хөтөлбөрийн хүрээн дэх олон улсын хамтын ажиллагаа, түншлэл

7.1 Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон бусад НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудтай хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн сайжруулах техникийн дэмжлэг, туслалцаа авч, хамтран ажиллахыг эрмэлзэнэ.

7.2. Улс орнуудын Засгийн газар, түүний олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн сайжруулах чиглэлээр санхүүгийн болон техникийн туслалцаа, тусламж, дэмжлэг авах чиглэлээр хамтран ажиллана.

Найм. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

8.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ажилтны болон ажил олгогчийн төлөөллийн байгууллага, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

8.2 Аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд хөтөлбөрийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг тухайн шатны Засаг дарга, ХАБЭА-н зөвлөлтэй хамтран гүйцэтгэж, тайлангаа хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

8.3 Салбарын түвшин дэх хөтөлбөрийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг тухайн салбарын яамдын ХАБЭА-н салбар хороо гүйцэтгэж, тайлангаа хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

8.4 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, хяналт-шинжилгээ үнэлгээг жил бүр хийж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хороонд танилцуулна.

8.5 Үр дүнгийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмж нь холбогдох бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах үндэслэл болно.

8.6 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөтөлбөр хэрэгжиж дууссаны дараа үр дүнгийн үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлж болно.

8.7 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, түүний үр дүнгийн талаарх мэдээ, тайланг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан ил тод, нээлттэй мэдээлнэ.